

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 1 дүгээр сарын
....-ны өдөр

Улаанбаатар хот

**ИРГЭДИЙН ТЭТГЭВЭР БАРЬЦААЛСАН ЗЭЭЛИЙН ТӨЛБӨРИЙГ
ТӨРӨӨС НЭГ УДАА ТӨЛӨХ ТУХАЙ****1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагч болон цэргийн алба хаасны тэтгэвэр авагч иргэдийн тэтгэвэр барьцаалан банкнаас авсан зээлийн үлдэгдэл төлбөрийг төрөөс нэг удаа хариуцан төлөхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл.Тэтгэврийн зээлийн төрөөс нэг
удаа төлөхтэй холбоотой хууль тогтоомж**

2.1.Иргэдийн тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“тэтгэвэр барьцаалсан зээл” гэж энэ хуулийн 3.1.2-т заасан иргэний тэтгэврээ барьцаалан банкнаас гэрээний үндсэн дээр зээлсэн мөнгөн хөрөнгийг;

3.1.2.“тэтгэвэр авагч” гэж Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1, 2.2, 2.3 дахь хэсэг, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 3 дахь заалтад тус тус хамаарах тэтгэвэр авагч иргэнийг.

4 дүгээр зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

4.1.Энэ хуулийн үйлчлэлд 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд тэтгэвэр барьцаалсан зээл авсан, зээлийн төлбөрийн үлдэгдэлтэй энэ хуулийн 3.1.2-т заасан Монгол Улсын иргэн хамаарна.

4.2.Тэтгэвэр авагч нь зээлийн төлбөрөө барагдуулж байх хугацаандаа нас барсан бол түүний 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацааны зээлийн үлдэгдэл төлбөрийг энэ хуулийн үйлчлэлд хамруулна.

4.3.Тэтгэвэр авагч нь 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс өмнө тэтгэвэр барьцаалсан зээл авч зээлийн төлбөрөө бүрэн барагдуулсан бол энэ хуулийн үйлчлэлд хамаарахгүй.

5 дугаар зүйл. Тэтгэвэр барьцаалсан зээлийг төлөх арга хэмжээ, түүний санхүүжилтийн эх үүсвэр

5.1.Төрийн өмчит Эрдэнэс Монгол ХХК тэтгэвэр барьцаалсан зээлийн үлдэгдэл төлбөрийн санхүүжилтийг өөрийн охин компаний Салхитын мөнгө, алтны ордын эдийн засгийн эргэлтэд оруулсан орлогоос төрд ногдох өгөөжийг барьцаалан энэ хуулийн 3.1.2-т заасан иргэний банкинд төлөх тэтгэвэр барьцаалсан зээлийн үлдэгдлийн хэмжээгээр үнэт цаас гаргаж төлнө.

5.2.Төрийн өмчит Эрдэнэс Монгол ХХК иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн үүргийг үнэт цаас гаргаж төлөх гэрээг холбогдох банк тус бүртэй байгуулна.

5.3.Монгол Улсын Хөгжлийн банк энэ хуулийн 5.1-д заасан үнэт цаасанд хууль тогтоомжид нийцүүлэн бие даан баталгаа гаргана.

5.4.Монголбанк энэ хуулийн 5.1-д заасан үнэт цаасыг Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2, 4 дэх заалтад заасан хэрэгслийг ашиглан худалдан авна.

5.5.Тэтгэврийн зээлийг төлөхтэй холбоотойгоор энэ хуулийн 5.1-д заасан төрийн өмчит компани зээл авах болон үнэт цаас гаргахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 16 дахь хэсэгт заасан зөвшөөрлийг авахгүй.

5.6.Энэ хуулийн 5.4-д заасны дагуу үнэт цаас эзэмшсэнээс Монголбанкны өөрийн хөрөнгө буурсан тохиолдолд Засгийн газар үнэт цаас гаргаж Монголбанкинд эзэмшүүлэх замаар нөхнө.

6 дугаар зүйл. Тэтгэвэр барьцаалсан зээлийг төлөх журам

6.1.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас тэтгэвэр авагчийн мэдээллийг харилцагч банкинд хүргүүлнэ.

6.2.Банк нь тэтгэвэр авагчийн зээлийн үлдэгдэл төлбөрийг баталгаажуулж, мэдээллийг тэтгэвэр авагч болон нийт дүнгээр нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

6.3.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ зүйлийн 6.2-т заасан мэдээллийг банк тус бүрээр Төрийн өмчит Эрдэнэс Монгол ХХК-д хүргүүлнэ.

6.4.Энэ хуулийн 5.2-т заасан гэрээ байгуулснаар зээлийн төлбөрийн үүрэг дуусгавар болсонд тооцно.

7 дугаар зүйл. Үйл ажиллагааны хяналт, тайлагналт

7.1.Төрийн аудитын байгууллага нь энэ хуулийн хэрэгжилтэд аудит хийж, тайланг Улсын Их Хурал, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулна.

8 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

8.1.Энэ хуулийг 2020 оны ... дүгээр сарын ...-ны өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 1 дүгээр сарын
....-ны өдөр

Улаанбаатар хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 29.4 дэх хэсгийн "суутгал хийхийг" гэснийг "суутгал хийх, барьцаалахыг" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2020 оны дүгээр сарын-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө."

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 1 дүгээр сарын
....-ны өдөр

Улаанбаатар хот

**АХМАД НАСТНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Ахмад настны тухай хуулийн 6.9 дэх хэсгийг “тэтгэвэр, тэтгэмж” гэснийг хассугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2020 оны дүгээр сарын-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 1 дүгээр сарын
....-ны өдөр

Улаанбаатар хот

БАНК, ЭРХ БҮХИЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МӨНГӨН ХАДГАЛАМЖ, ТӨЛБӨР ТООЦОО, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд доор дурдсан агуулгатай 29.9 дэх хэсэг нэмсүгэй:

"29.9. Зээлдүүлэгч зээлдэгчийн тэтгэвэр, тэтгэмжийг барьцаалахыг хориглоно."

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2020 оны дүгээр сарын-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ